



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Боловсролын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: **СЭА-2022/225-НА-СТА-ТШЗ**

<p>Цахим хуудас: www.selenge@audit.gov.mn Сүхбаатар сум 2022 он</p>	<p>Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа Утас: 7036-3040 Цахим хаяг: enkhtuyach@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер: Б.Батмөнх Утас: 7036-3036 Цахим хаяг: batmunkhb@audit.gov.mn</p> <p>Аудитор: О.Анхбаяр Утас: 7036-2442 Цахим хаяг: ankhbayaro@audit.gov.mn</p>
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1.Аудитын санал дүгнэлт	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	6
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	7
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	9
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	11
3. Аудитын тайлан.....	12
3.1 Ерөнхий зүйл	12
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт.....	12
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	13
3.4 Материаллаг байдал.....	13
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	13
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	15
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	16
3.8 Аудитын гол асуудал.....	16
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	16
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	16
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	16
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал	17
4. Аудитын илрүүлэлт	17
4.1 Залруулсан алдаа	17
4.2 Албан шаардлага	17
4.3 Зөвлөмж.....	17
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	18

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
БСШУСЯ	Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам
ЗГНХ	Засгийн газрын нөөц хөрөнгө
ЗДНХ	Засаг даргын нөөх хөрөнгө
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ТЗ	Төрийн захиргаа
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ТҮ	Төрийн үйлчилгээ
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ҮОМШӨ	Үйлдвэрлэлийн осол мэргэжлээс шалтгаалах өвчин
ШУ	Шинжлэх ухаан



СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

213200 Сэлэнгэ аймаг, Сүхбаатар сум
Цагаан Эрэг II баг
Утас: 7036-3040, Факс: (976)-7036-3040
E-mail: Selenge@audit.gov.mn

2022.02.23 № СЭА-2022/225-НА-СТА-ТШЗ
танай _____-ны № _____-т

СЭЛЭНГЭ АЙМГИЙН
БОЛОВСРОЛЫН ГАЗРЫН
ДАРГА Ч.ЖАРГАЛСАЙХАН ТАНАА

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сэлэнгэ аймгийн Боловсролын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Сэлэнгэ аймгийн Боловсролын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	9,442,149.00	10,236,739.00
33	АВЛАГА	92,400.00	0.00
33500	Бусад авлага	92,400.00	0.00
33510	Байгууллагаас авах авлага	92,400.00	0.00
34	УРЬДЧИЛГАА	742,000.00	0.00
34600	Урьдчилж гарсан зардал	742,000.00	0.00
35	БАРАА МАТЕРИАЛ	8,607,749.00	10,236,739.00
35400	Хангамжийн материал	8,607,749.00	10,236,739.00
35420	Аж ахуйн материал	8,032,749.00	10,236,739.00
35440	Түлш, шатах тослох материал	575,000.00	0.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	178,204,908.33	242,756,929.80
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	178,204,908.33	242,756,929.80
39200	Биет хөрөнгө	178,204,908.33	242,756,929.80
39203	Авто-тээврийн хэрэгсэл	69,821,075.00	69,821,075.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-39,487,741.69	-8,866,666.73
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	254,235,326.98	231,971,099.78
39206	Хуримтлагдсан элэгдэл	-111,566,094.17	-66,582,871.78
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	27,333,793.73	26,406,220.49
39208	Хуримтлагдсан элэгдэл	-22,901,451.52	-10,761,926.96
39217	Ном	770,000.00	770,000.00
39301	Программ хангамж	1,155,000.00	0.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-1,155,000.00	0.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	187,647,057.33	252,993,668.80
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	88,400.00	50,000.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	88,400.00	50,000.00
41300	Өглөг	88,400.00	50,000.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	2,000.00	50,000.00
41360	Бусад өглөг	86,400.00	0.00
41361	Байгууллагад төлөх өглөг	86,400.00	0.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	187,558,657.33	252,943,668.80
51	Засгийн газрын хувь оролцоо	187,558,657.33	252,943,668.80
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	211,787,128.44	0.00
51101	Өмч /төрийн/ /ТӨҮГ/	0.00	211,787,128.44
51200	Хуримтлагдсан үр дүн	-25,628,575.56	41,156,540.36
51210	Өмнөх үеийн үр дүн	-159,408,819.13	-24,228,471.11
51220	Тайлант үеийн үр дүн	133,780,243.57	65,385,011.47
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,400,104.45	0.00
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	187,647,057.33	252,993,668.80

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2,729,114,633.22	2,678,059,716.45
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	268,690,830.22	182,991,201.45
120	Нийтлэг татварын бус орлого	268,690,830.22	182,991,201.45
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	206,096,820.22	167,642,901.45
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	206,096,820.22	167,642,901.45
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	62,364,010.00	5,861,300.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	230,000.00	9,487,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,460,423,803.00	2,495,068,515.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	2,432,045,600.00	2,227,153,400.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,432,045,600.00	2,227,153,400.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	28,378,203.00	267,915,115.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0.00	1,921,350.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	27,006,235.00	257,760,215.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	1,371,968.00	8,233,550.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2,595,177,097.99	2,612,383,552.68
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,595,177,097.99	2,612,383,552.68
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	524,073,472.97	731,615,589.39
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	279,081,081.52	261,812,878.88
210101	Үндсэн цалин	198,084,047.55	188,615,123.30
210102	Нэмэгдэл	55,562,748.17	48,668,809.51
210103	Унаа хоолны хөнгөлөлт	9,217,100.00	11,337,500.00
210104	Урамшуулал	16,217,185.80	13,191,446.07
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	35,413,568.46	35,094,530.92
210201	Тэтгэврийн даатгал	24,117,935.14	24,503,414.27
210202	Тэтгэмжийн даатгал	2,621,663.57	2,719,389.01
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,470,610.88	2,099,743.42
210204	Ажилгүйдлийн даатгал	563,942.74	524,725.76
210205	Эрүүл мэндийн даатгал	5,639,416.13	5,247,258.46
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	23,090,608.00	22,911,540.91
210301	Гэрэл, цахилгаан	3,877,584.00	3,711,454.91
210302	Түлш, халаалт	18,577,532.00	18,470,356.00
210303	Цэвэр, бохир ус	635,492.00	729,730.00
2104	Хангамж, бараа материалын зардал	105,177,802.72	132,007,081.68
210401	Бичиг хэрэг	1,104,100.00	12,703,795.00
210402	Тээвэр, шатахуун	3,705,000.00	4,196,350.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	576,230.00	2,527,390.00
210404	Ном, хэвлэл	1,230,000.00	240,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	381,300.00	19,191,200.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,205,100.00	691,750.00
210408	Бараа материал акталсны зардал	0.00	341,260.00
210409	Бараа материал шилжүүлсний зардал	96,976,072.72	92,115,336.68

2106	Эд хогшил, урсгал засварын зардал	252,950.00	4,693,500.00
210604	Урсгал засвар	252,950.00	4,693,500.00
2107	Томилолт, зочны зардал	4,844,200.00	1,400,500.00
210702	Дотоод албан томилолт	4,844,200.00	1,400,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	30,205,295.00	209,731,115.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	30,205,295.00	208,361,070.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	0.00	1,008,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	0.00	200,925.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	0.00	98,120.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	0.00	63,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	46,007,967.27	63,964,442.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	325,245.00	328,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	12,839,900.00	14,021,851.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	32,842,822.27	49,614,591.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,071,103,625.02	1,880,767,963.29
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,003,138,996.00	1,678,799,147.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	1,218,123,264.00	744,422,153.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	783,735,732.00	934,049,394.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,280,000.00	327,600.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	67,964,629.02	201,968,816.29
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	67,953,661.02	201,932,816.29
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	10,968.00	36,000.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	133,937,535.23	65,676,163.77
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	157,291.66	291,152.30
225001	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны гарз	157,291.66	291,152.30
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	133,780,243.57	65,385,011.47

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	211,787,128.44	1,400,104.45	-159,408,819.13	53,778,413.76
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	211,787,128.44	1,400,104.45	-159,408,819.13	53,778,413.76
9	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	133,780,243.57	133,780,243.57
10	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	211,787,128.44	1,400,104.45	-25,628,575.56	187,558,657.33
11	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	211,787,128.44	1,400,104.45	-25,628,575.56	187,558,657.33
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	1,400,104.45	1,400,104.45
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	211,787,128.44	1,400,104.45	-24,228,471.11	188,958,761.78
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0.00	-1,400,104.45	0.00	-1,400,104.45
19	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	65,385,011.47	65,385,011.47
20	2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	211,787,128.44	0.00	41,156,540.36	252,943,668.80

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	2,468,088,203.00	2,495,068,515.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,468,088,203.00	2,495,068,515.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	2,432,045,600.00	2,227,153,400.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,432,045,600.00	2,227,153,400.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	36,042,603.00	267,915,115.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0.00	1,921,350.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	27,006,235.00	257,760,215.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	9,036,368.00	8,233,550.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,466,488,203.00	2,471,213,015.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,466,488,203.00	2,471,213,015.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	395,384,577.98	590,445,051.71
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	279,079,081.52	261,764,878.88
210101	Үндсэн цалин	198,084,047.55	188,567,123.30
210102	Нэмэгдэл	55,560,748.17	48,668,809.51
210103	Унаа хоолны хөнгөлөлт	9,217,100.00	11,337,500.00
210104	Урамшуулал	16,217,185.80	13,191,446.07
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	35,505,968.46	35,002,130.92
210201	Тэтгэврийн даатгал	24,189,335.14	24,432,854.27
210202	Тэтгэмжийн даатгал	2,625,023.57	2,715,189.01
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,479,010.88	2,091,343.42
210204	Ажилгүйдлийн даатгал	564,782.74	523,885.76
210205	Эрүүл мэндийн даатгал	5,647,816.13	5,238,858.46
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	23,090,608.00	22,911,540.91
210301	Гэрэл, цахилгаан	3,877,584.00	3,711,454.91
210302	Түлш, халаалт	18,577,532.00	18,470,356.00
210303	Цэвэр, бохир ус	635,492.00	729,730.00
2104	Хангамж, бараа материалын зардал	8,499,330.00	38,985,285.00
210401	Бичиг хэрэг	787,700.00	12,790,195.00
210402	Тээвэр, шатахуун	4,280,000.00	3,621,350.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	576,230.00	2,527,390.00
210404	Ном, хэвлэл	1,230,000.00	240,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	381,300.00	19,117,600.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,244,100.00	688,750.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	252,950.00	5,161,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	0.00	467,500.00
210604	Урсгал засвар	252,950.00	4,693,500.00
2107	Томилолт, зочны зардал	5,586,200.00	658,500.00
210702	Дотоод албан томилолт	5,586,200.00	658,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	30,205,295.00	211,611,865.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	30,205,295.00	210,241,820.00

210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	0.00	1,008,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	0.00	200,925.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	0.00	98,120.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	0.00	63,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	13,165,145.00	14,349,851.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	325,245.00	328,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	12,839,900.00	14,021,851.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,071,103,625.02	1,880,767,963.29
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,003,138,996.00	1,678,799,147.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	1,218,123,264.00	744,422,153.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	783,735,732.00	934,049,394.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,280,000.00	327,600.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	67,964,629.02	201,968,816.29
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	67,953,661.02	201,932,816.29
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	10,968.00	36,000.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	1,600,000.00	23,855,500.00
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	1,600,000.00	23,855,500.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1,600,000.00	23,855,500.00
2200	Дотоод эх үүсвэрээр	1,600,000.00	23,855,500.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	1,600,000.00	23,855,500.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-1,600,000.00	-23,855,500.00

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	Гүйцэтгэл зөрүү /хэтрэлт, хэмнэлт/	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,227,153,400.00	2,025,220,583.71	-201,932,816.29	90.93
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,227,153,400.00	2,025,220,583.71	-201,932,816.29	90.93
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	355,361,900.00	346,421,436.71	-8,940,463.29	97.48
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	269,009,400.00	261,764,878.88	-7,244,521.12	97.31
210101	Үндсэн цалин	183,951,400.00	188,567,123.30	4,615,723.30	102.51
210102	Нэмэгдэл	55,541,600.00	48,668,809.51	-6,872,790.49	87.63
210103	Унаа хоолны хөнгөлөлт	12,672,000.00	11,337,500.00	-1,334,500.00	89.47
210104	Урамшуулал	16,844,400.00	13,191,446.07	-3,652,953.93	78.31
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	36,316,300.00	35,002,130.92	-1,314,169.08	96.38
210201	Тэтгэврийн даатгал	25,555,900.00	24,432,854.27	-1,123,045.73	95.61
210202	Тэтгэмжийн даатгал	2,690,100.00	2,715,189.01	25,089.01	100.93
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,152,100.00	2,091,343.42	-60,756.58	97.18
210204	Ажилгүйдлийн даатгал	538,000.00	523,885.76	-14,114.24	97.38
210205	Эрүүл мэндийн даатгал	5,380,200.00	5,238,858.46	-141,341.54	97.37
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	22,932,200.00	22,911,540.91	-20,659.09	99.91

Сэлэнгэ аймгийн Боловсролын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210301	Гэрэл, цахилгаан	3,633,000.00	3,711,454.91	78,454.91	102.16
210302	Түлш, халаалт	18,464,300.00	18,470,356.00	6,056.00	100.03
210303	Цэвэр, бохир ус	834,900.00	729,730.00	-105,170.00	87.40
2104	Хангамж, бараа материалын зардал	6,640,900.00	6,636,440.00	-4,460.00	99.93
210401	Бичиг хэрэг	757,500.00	756,700.00	-800.00	99.89
210402	Тээвэр, шатахуун	2,904,600.00	2,900,000.00	-4,600.00	99.84
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	277,400.00	277,390.00	-10.00	100.00
210404	Ном, хэвлэл	245,600.00	240,000.00	-5,600.00	97.72
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	93,600.00	93,600.00	0.00	100.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,362,200.00	2,368,750.00	6,550.00	100.28
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,693,600.00	4,693,500.00	-100.00	100.00
210604	Урсгал засвар	4,693,600.00	4,693,500.00	-100.00	100.00
2107	Томилолт, зочны зардал	671,900.00	658,500.00	-13,400.00	98.01
210702	Дотоод албан томилолт	671,900.00	658,500.00	-13,400.00	98.01
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,861,600.00	5,694,345.00	-167,255.00	97.15
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,327,900.00	4,324,300.00	-3,600.00	99.92
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,152,000.00	1,008,000.00	-144,000.00	87.50
210803	Даатгалын үйлчилгээ	212,700.00	200,925.00	-11,775.00	94.46
210804	Тээврийн хэрэгслийн татвар	105,000.00	98,120.00	-6,880.00	93.45
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	64,000.00	63,000.00	-1,000.00	98.44
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	9,236,000.00	9,060,101.00	-175,899.00	98.10
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	500,000.00	328,000.00	-172,000.00	65.60
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	8,736,000.00	8,732,101.00	-3,899.00	99.96
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,871,791,500.00	1,678,799,147.00	-192,992,353.00	89.69
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,871,791,500.00	1,678,799,147.00	-192,992,353.00	89.69
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	921,719,300.00	744,422,153.00	-177,297,147.00	80.76
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	949,744,200.00	934,049,394.00	-15,694,806.00	98.35
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	328,000.00	327,600.00	-400.00	99.88
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,227,153,400.00	2,025,220,583.71	-201,932,816.29	90.93
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	2,227,153,400.00	2,025,220,583.71	-201,932,816.29	90.93
310001	Улсын төсвөөс санхүүжих	2,227,153,400.00	2,025,220,583.71	-201,932,816.29	90.93

6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	45.00	43.00	-2.00	95.56
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.00	0.00	100.00
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00	0.00	100.00
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	22.00	21.00	-1.00	95.45
620001	Удирдах ажилтан	1.00	1.00	0.00	100.00
620002	Гүйцэтгэх ажилтан	18.00	14.00	-4.00	77.78
620003	Үйлчлэх ажилтан	3.00	6.00	3.00	200.00
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	22.00	21.00	-1.00	95.45
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	13.00	14.00	1.00	107.69
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	9.00	7.00	-2.00	77.78

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	267,915,115.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	267,915,115.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	267,915,115.00
2104	Хангамж, бараа материалын зардал	34,028,845.00
210401	Бичиг хэрэг	12,033,495.00
210402	Тээвэр, шатахуун	721,350.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,250,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	19,024,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	18,964,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	18,964,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	209,596,520.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	209,596,520.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	5,289,750.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5,289,750.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	36,000.00
213303	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг	36,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	267,915,115.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	267,915,115.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,921,350.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	257,760,215.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	8,233,550.00

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Сэлэнгэ аймгийн Боловсролын газар *Цаашид Боловсролын газар гэх/-ын* 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд анхан шатны баримт, төлбөрийн цахим баримттай холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор О.Анхбаяр гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Боловсролын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 19 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Боловсролын газрын эрхэм зорилго нь *“Боловсролын үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлж, хүүхэд залуучуудад чанартай боловсрол олгох, иргэдэд зах зээлийн нөхцөлд амьдрах арга ухаанд суралцах таатай орчин нөхцөлийг бүрдүүлэх”*-д оршиж байна.

Боловсролын газрын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Боловсролын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг орон нутгийн хэмжээнд зохион байгуулах,
- Боловсролын хөгжлийн бодлого, хууль тогтоомж, шийдвэрийг байгууллага, олон нийтэд сурталчлан таниулах, хэрэгжилтийг зохион байгуулах, тэдгээрийг сургууль, цэцэрлэгт хэрэгжүүлэхэд мэргэжил, арга зүй, удирдлагын дэмжлэг үзүүлэх, тайлагнах,
- Шинээр батлагдсан эрх зүйн баримт бичиг, хууль тогтоомжийн хэрэгжилт болон цаг үеийн бусад асуудлаар цэцэрлэг, сургуулийн удирдах ажилтанд мэдээлэл өгөх, солилцох (уулзалт, онлайн хурал, сургалт/семинар, хэлэлцүүлэг гэх мэт) үйл ажиллагааг тогтмол хэрэгжүүлэх.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Монгол Улсын 2021 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилттэй холбоотой,
- Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар” шинэчлэгдсэн,
- Сангийн сайдын дэргэдэх Нягтлан бодох бүртгэл, аудитын стандартын хорооны 2020 оны 10 дугаар тогтоолоор батлагдсан УСНББОУС-ын өөрчлөлт шинэчлэл хийгдсэн гэх мэт.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэлийн үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзэж байна.

Тус байгууллагын үйл ажиллагаанд мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Тайлант онд дээд шатны төсвийн захирагчийн зүгээс санхүүгийн хяналт шалгалт, дотоод аудит хийгдээгүй байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Боловсролын газрын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн, хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 2,595,177.1 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 25,951.8 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу **18.166.2** мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж, шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Боловсролын газрын 2021 оны санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 65,297.8 мянган төгрөгөөр буюу 34.7 хувиар өссөн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс бараа материал, үндсэн хөрөнгө, засгийн газрын оролцоо дансад материаллаг өөрчлөлт гарсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө			
Авлага	92.4		(92.4)
Урьдчилгаа	742.0		(742.0)
Бараа материал	8,607.8	10,236.7	1,628.9
Үндсэн хөрөнгө	178,204.9	242,756.9	64,552.0
Нийт хөрөнгө	187,647.1	252,993.6	65,346.5
Өр төлбөр	88.4	50.0	(38.4)
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	187,558.7	252,943.6	65,384.9
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	187,647.1	252,993.6	65,346.5

Бараа материалын данс 10,236.7 мянган төгрөг болж 1,628.9 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 110,560.2 мянган төгрөгийн бараа материал худалдан авсан болон 341.4 мянган төгрөгийн бараа материалыг акталж, байгууллагын үйл ажиллагаанд 108,589.9 мянган төгрөгийн бараа материал зарцуулснаас шалтгаалсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл /анхны өртгөөр/ 328,968.4 мянган төгрөг болж өмнөх оноос 24,346.8 мянган төгрөгөөр буурсан нь урсгал төсвийн санхүүжилтээр 23,855.5 мянган төгрөгийн тоног төхөөрөмж худалдан авсан болон Азийн хөгжлийн банкны санхүүжилттэй “Ажил мэргэжлийн чиг баримжаа, мэдээллийн төв” төслөөс 5,861.3 мянган төгрөгийн тоног төхөөрөмж үнэ төлбөргүй хүлээн авч, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2021 оны 11, 43 дугаар тогтоолуудаар 15,454.0 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмжийг акталж, 38,609.6 мянган төгрөгийн хөрөнгийг нэр бүхий 28 байгууллагад шилжүүлснээс тус тус шалтгаалсан байна.

Мөн аймгийн Орон нутгийн өмчийн газрын 2021 оны 646 дугаар албан бичгийг үндэслэн 84,740.9 мянган төгрөгийн элэгдлээрээ анхны үнээ нөхсөн боловч цаашид ашиглах боломжтой 43 нэр төрлийн 100 хөрөнгийн анхны үнэ, ашиглалтын хугацааг шинэчлэн тогтоож, дансанд бүртгэсэн байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 252,943.6 мянган төгрөг болж 65,384.9 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалсан байна.

Санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 51,054.9 мянган төгрөгөөр буюу 1.9 хувиар буурсан нь үнэ төлбөргүй хүлээн авсан орлого 121,355.8 мянган төгрөгөөр, урсгал үйл ажиллагааны санхүүжилт 267,915.1 мянган төгрөгөөр буурсан зэргээс голлон шалтгаалсан байна.

Нийт зардал өмнөх оноос 17,206.4 мянган төгрөгөөр буюу 0.7 хувиар өссөн нь бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний зардал, хөдөө орон нутагт тогтвор

суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг зэрэг зардлууд өссөнөөс голлон шалтгаалсан байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр болон нийт зарлагыг 514,074.7 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлснийг урсгал зардлыг 165,016.5 мянган төгрөгөөр бууруулж, тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмжийн 921,719.3 мянган төгрөг, хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласны тэтгэмжийн 949,744.2 мянган төгрөгөөр тус тус нэмэгдүүлж 2,220,521.7 мянган төгрөгөөр баталсан байна.

Төсвийн жилийн эцэст батлагдсан төсөвт өөрчлөлт оруулж, 6,631.7 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн **2,227,153.4** мянган төгрөгөөр эцэслэн баталсан нь урсгал засварын зардлыг 4,500.0 мянган төгрөгөөр, тогтмол зардлыг 2,057.6 мянган төгрөгөөр, бусад зардлыг 71.1 мянган төгрөгөөр нэмэгдүүлснээс шалтгаалсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх сургуулийн өмнөх боловсрол, ерөнхий боловсрол, боловсрол, ШУ-ны бодлого удирдлага зэрэг 3 хөтөлбөрийн 4 арга хэмжээг улсын төсвөөс санхүүжүүлэхээр 2,227,153.4 мянган төгрөг төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр 2,227,153.4 мянган төгрөгийн санхүүжилт авч урсгал үйл ажиллагаанд **2,025,220.6** мянган төгрөгийг зарцуулж, оны эцэст 201,932.8 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд БСШУСЯ-наас хүүхэд харах үйлчилгээ, ариутгалын зардал, сургуулийн тэтгэлэгт хөтөлбөр -5, бүсийн сургалтын зардал, контент боловсруулах лаборатори байгуулах зэрэг 265,993.8 мянган төгрөг, Япон улсын Жайка олон улсын байгууллагаас Сэлэнгэ аймгийн боловсролын байгууллагуудад хандивласан ариутгалын бодис, тоног төхөөрөмжийг тээвэрлэх зардалд аймгийн ЗДТГ-аас

шилжүүлсэн 1,921.3 мянган төгрөг зэрэг 267,915.1 мянган төгрөгийн санхүүжилт авч, зориулалтын дагуу зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тайлант онд онцлох бусад асуудал байхгүй.

3.8 Аудитын гол асуудал

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд байхгүй болно.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд Боловсролын газрын мэдээлбэл зохих 22 төрлийн 175 мэдээллийг хугацаанд нь бүрэн мэдээлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.9.2 Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын хэрэгжилт

Боловсролын газар нь тайлант онд үндсэн үйл ажиллагаанд 2,227,153.4 мянган төгрөгийн төсөв батлагдаж, гүйцэтгэлээр 2,025,220.6 мянган төгрөгийг зарцуулан, төсвийн төлөвлөгөөг **9.1** хувиар хэмнэсэн нь ЗГ-ын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.1-д: “.....батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах” гэж заасныг бүрэн хэрэгжүүлээгүй байна.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар тогтоосон 807.7 мянган төгрөгийн 1 албан шаардлагыг бүрэн биелүүлсэн байна. Аудитаар өгсөн 1 зөвлөмжийн хэрэгжилт 100 хувьтай байна.

Хүснэгт 2. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Хэрэгжилтийн хувь
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	1	807.7	1	807.7	100.0
Зөвлөмж	1	0.0	1	0.0	100.0
Нийт дүн	2	807.7	2	807.7	100.0

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал гараагүй болно.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт **4,563.2** мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 100.1 мянган төгрөгийн алдааг залруулж, 145.4 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлэн, 4,317.7 мянган төгрөгийн алдаа зөрчилд 1 зөвлөмж өгсөн.

4.1 Залруулсан алдаа

- Үндсэн хөрөнгийн элэгдлийг **100.1** мянган төгрөгөөр дутуу тооцсоныг санхүүгийн тайланд залруулга хийв.

4.2 Албан шаардлага

1. Нягтлан бодогчийн тооцооллын алдаанаас шалтгаалан нэр бүхий 2 албан хаагчид **145.4** мянган төгрөгийн хавсран ажилласны нэмэгдэл илүү олгосон нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-дахь "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэсэн заалтыг зөрчсөн бөгөөд санхүүгийн тайлангийн "Нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: 2022 оны цалингаас нөхөн суутгах албан шаардлага хүргүүлэх.

4.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Анхан шатны баримт, төлбөрийн цахим баримттай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт: Тайлант онд **4,317.7** мянган төгрөгийн бараа материалын худалдан авалтыг холбогдох үзүүлэлтүүдийг тусгасан төлбөрийн баримтаар баталгаажуулаагүй, цахим системд шивэгдээгүй байна.

1.2. Өгсөн зөвлөмж: Энэ нь Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйл 28.5 дахь "Татвар төлөгч борлуулалт хийх тухай бүрд хэрэглэгчийн системээс дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг хэвлэж өгөх, эсхүл цахимаар илгээх үүрэгтэй" гэсэн заалтыг болон Сангийн сайдын 2017 оны 347

дугаар тушаал 1 дүгээр хавсралтын 6.5 дахь “Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм. Төлбөрийн баримтад борлуулагч, худалдан авагчийг таних тэмдэг, татвар төлөгчийн дугаар, төлбөр тооцоо хийгдсэн он, сар, өдөр, бараа, ажил, үйлчилгээний нэр, код, тоо хэмжээ, үнэ, татварын дүнг тусгана. Төлбөрийн баримтыг цахим гарын үсэг эсхүл тусгай нууцлалын QR кодоор баталгаажуулах бөгөөд Монгол Улсын Стандарт MNS 6529:2015 “Татварын нэгдсэн системд ашиглах төлбөрийн баримтын ерөнхий шаардлага”-д заасан загварын дагуу бүртгэлийн машинаар хоёр хувь үйлдэнэ” гэж заасныг зөрчсөн ба “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул цаашид төлбөрийн цахим баримтыг үндэслэж, ажил гүйлгээг гүйцэтгэж, бүртгэх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 06 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Боловсролын газар	3	4,563.2	1	100.1			1	145.4	1	4,317.7